



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

Хяналт, үнэлгээ хийх тухай

Монгол Улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Эрүүл мэндийн сайдын 2012 оны “Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн журам батлах тухай” 41 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, худалдах, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй болон улсын бүртгэлд бүртгүүлсэн байгууллага, хүнсний сүлжээ дэлгүүр, эмийн санд хяналт, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, чанар аюулгүй байдалд Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтарсан удирдамж батлуулж, хяналт, үнэлгээг 2013 оны 10 дугаар сард багтаан гүйцэтгэж, дүнг Биологийн идэвхт бүтээгдэхүүний салбар зөвлөлийн хуралд танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын, Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга (Ч.Мөнхдэлгэр)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.

САЙД



Н.УДВАЛ

41
Эрүүл мэндийн сайдын
2013 оны 09 дугаар сарын 09-ны
өдрийн 318 дүгээр тушаалын
1 дүгээр хавсралт

БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
БҮРТГЭЛ, ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ,
ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Ч.Мөнхдэлгэр

ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

О.Оюунчимэг

ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн
мэргэжилтэн

Гишүүд:

Д.Чулуунцэцэг

ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн
мэргэжилтэн

Д.Бямбадорж

ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн
мэргэжилтэн

Д.Ганзориг

ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Баярболд

МХЕГ-ын Эрүүл мэнд, боловсролын хяналтын хэлтсийн
дарга (тохиролцсоноор)

Д.Алтантуяа

МХЕГ-ын Эм био бэлдмэлийн хяналтын улсын ахлах
байцаагч (тохиролцсоноор)

Ч.Түмэнхүү

МХЕГ-ын Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын
улсын ахлах байцаагч (тохиролцсоноор)

Ж.Мөнхцэцэг


НМХГ-ын Эм био бэлдмэлийн хяналтын улсын ахлах
байцаагч (тохиролцсоноор)

Н.Одончимэг

НМХГ-ын Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын
улсын байцаагч (тохиролцсоноор)

Нийслэлийн 6 дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын
хэлтсийн эм био бэлдмэл, хүнсний эрүүл ахуйн
хяналтын улсын (ахлах) байцаагчид (тохиролцсоноор)

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 09 дугаар сарын 04-ны
өдрийн 318 дүгээр тушаалын
2 дугаар хавсралт



БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БҮРТГЭЛ
ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1.Биологийн идэвхт бүтээгдэхүүн улсын бүртгэлд бүртгүүлсэн, импортлох, худалдах, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага:

Ерөнхий мэдээлэл

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	БИБХНБ-ын нэр, утас	
2	ТЗ-ийн гэрчилгээний дугаар	
3	ТЗ-ийн гэрчилгээний хүчинтэй хугацаа	
4	ТЗ-ийн гэрчилгээ эзэмшигчийн нэр	
5	ТЗ-ийн гэрчилгээнд заасан хаяг	
6	Одоо байгаа байршлын хаяг	
7	Салбарын тоо /худалдан борлуулах цэгүүд/	
8	Салбарын байршил /дүүрэг нэр/	
9	Удирдах албан тушаалтны мэргэжил, ажилласан жил	
10	Хүн хүчний хангамж /Нийт ажилчдын тоо, үүнээс эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг хүний тоо, нэр, мэргэжлийг бичих/	

Бүртгэлийн байдал

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Улсын бүртгэлд бүртгүүлсэн БИБ-ний тоо; /бүртгэлийн гэрчилгээний хувийг авах/	
2	Анх бүртгүүлсэн савлалтын загвартай тохирч буй эсэх; /бүтээгдэхүүний нэр, тун хэмжээ, хэлбэр, үйлдвэрлэгчтэй тохирч буй эсэх, хүснэгт 1-ийн дагуу гаргах/	
3	Бүртгэлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа; /хүснэгт 1-ийн дагуу гаргах/	Сунгуулсан: Дууссан:
4	Улсын бүртгэлд бүртгэгдээгүй БИБ байгаа эсэх; / бүтээгдэхүүний нэр, тун хэмжээ, хэлбэр, үйлдвэрлэгч, улсаар нь хүснэгт 2-ийн дагуу гаргах/	
5	Хэзээ импортлосон талаарх мэдээлэл; /он, хилийн боомт/	

43

Чанар аюулгүй байдал		
№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	БИБ импортлох гэрээтэй эсэх;	
2	Үйлдвэрлэгчийн лабораторийн шинжилгээний дүн; /цувралын дугаар тохирсон эсэх, он/	
3	МХЕГ-ын НТЛ-ийн шинжилгээнд хамрагдсан эсэх; /он, үр дүн/	
4	Хугацаа дууссан БИБ байгаа эсэх; /бүтээгдэхүүний нэр, тун хэмжээ, хэлбэр, үйлдвэрлэгч, улсаар нь хүснэгт 3-ийн дагуу гаргах/	
5	БИБ-ийг үйлдвэрлэгчийн заасан горимын дагуу хадгалсан эсэх	
6	Бүтээгдэхүүний хэрэглэх заавар "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль"-ийн шаардлага хангасан эсэх	Хангасан:
		Хангаагүй:
7	Бүтээгдэхүүний савлалт, хаяглалт зөвшөөрөгдсөн хэл дээр байгаа эсэх;	Нийцсэн:
		Нийцээгүй:
8	Дотоодын хяналтын журамтай эсэх, илэрсэн зөрчил, авсан арга хэмжээг тэмдэглэдэг эсэх	

Танилцсан хүний нэр:

Утас:


он.....сар.....өдөр.....

Дүгнэлт:

2. Эмийн сан:

Ерөнхий мэдээлэл

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Эмийн сангийн нэр, утас	
2	ТЗ-ийн гэрчилгээний дугаар	
3	ТЗ-ийн гэрчилгээний хүчинтэй хугацаа	
4	ТЗ-ийн гэрчилгээнд заасан хаяг	
5	Одоо байгаа байршлын хаяг	



Бүртгэл, чанар аюулгүй байдал

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Худалдаалж буй БИБ-ний нэр, төрөл гаргах /бүтээгдэхүүний нэр төрөл, улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг хүснэгт 3-ийн дагуу гаргах/	
2	Баталгаатай зөвшөөрөл бүхий газраас авсан эсэх /гэрээ, падааныг шалгаж, хүснэгт 3-ийн дагуу гаргах /	
3	Улсын бүртгэлд бүртгэгдээгүй БИБ байгаа эсэх /хүснэгт 3-ийн дагуу гаргах /	
4	Хэрэв бүртгэлгүй БИБ байгаа бол худалдаж авсан эх үүсвэр / падааныг шалгаж, хүснэгт 3-ийн дагуу гаргах /	
5	Хугацаа дууссан БИБ бий эсэх /хүснэгт 3-ийн дагуу гаргах /	
6	БИБ-ийг горимын дагуу хадгалсан эсэх /лангуу болон агуулахад/	
7	Нөөцийн өрөөнд чийг, дулаан хэмжигчийн заалтыг өдөр бүр тэмдэглэдэг эсэх	
8	Дотоодын хяналтын журамтай эсэх, илэрсэн зөрчил, авсан арга хэмжээг тэмдэглэдэг эсэх	

Танилцсан хүний нэр:

Утас:


он.....сар.....өдөр.....

Дүгнэлт:

3.Хүнсний дэлгүүр:

Ерөнхий мэдээлэл

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Аж ахуй нэгжийн нэр	
2	Хаяг байршил, утас	
3	Хүн хүчний хангамж /Нийт ажилчдын тоо, үүнээс эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг хүний тоо, нэр, мэргэжлийг бичих/	



Бүртгэл, чанар аюулгүй байдал

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Худалдаалж буй БИБ-ний нэр, төрөл / бүтээгдэхүүний нэр төрөл, улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг хүснэгт 3-ийн дагуу гаргах/	
2	Баталгаатай зөвшөөрөл бүхий газраас авсан эсэх /гэрээ, падааныг шалгаж, хүснэгт 3-ийн дагуу гаргах /	
3	Улсын бүртгэлд бүртгэгдээгүй БИБ байгаа эсэх / хүснэгт 3-ийн дагуу гаргах /	
4	Хэрэв бүртгэлгүй БИБ байгаа бол худалдаж авсан эх үүсвэр / падааныг шалгаж, хүснэгт 3-ийн дагуу гаргах /	
5	Хугацаа дууссан БИБ бий эсэх /хүснэгт 3-ийн дагуу гаргах/	
6	БИБ-ийг горимын дагуу хадгалсан эсэх /лангуу болон агуулахад/	
7	Агуулахад чийг, дулаан хэмжигчийн заалтыг өдөр бүр тэмдэглэдэг эсэх	
8	Дотоодын хяналтын журамтай эсэх, илэрсэн зөрчил, авсан арга хэмжээг тэмдэглэдэг эсэх	

Танилцсан хүний нэр:

Утас:

он.....сар.....өдөр.....

Дүгнэлт: